

ЗАХ ХЯЗГААРЫГ ЦАГДАЖ СЭРГИЙЛЭХ ЦАГДАА НАРЫН ТҮР ДАГАЖ ЯВАХ ДҮРЭМ

**ГАДААД УЛСУУД ЛУГАА ЗАХ НИЙЛСЭН ОЛОН АЙМАГ ХОШУУДААС ХИЛ
ХАЗГААРААР СУУЛГАСАН ЦАГДАА НАРЫН ТҮР ДАГАЖ ЯВАХ ДҮРЭМ**

ХИЛ ХЯЗГААРЫГ ЭРХЛЭН ХАМГААЛАХ НЬ:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Хил хязгаарыг цагдаж сэргийлэх явдал хөнгөн бус газар орон ард олныг амгалан байдлыг сахиулах хүнд үүрэгтэй болох тул хөнгөвчилбөөс болох төдийгүй идэвхийлэн чармайн оролдож гүйцэтгэвээс зохимуй.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Элдэв цагдаа нар бээр тус тусын **ногсон** /ноогдуулах/ хэмжээний доторх хил хязгаарыг өөрийн үүрэг болгон хүлээж цаг ямагт харж сэргийлэн нутаг үндсийг гадаадад эзлэгдүүлэх шамшигдуулах ба хэрэг будлиан өдүүлэхэд хүргүүлэхгүй болговоос зохимуй.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Цагдаа нар бээр газар орны нутгийн ойр тохиолдох албан газрууд лугаа эрхбиш үргэлж хэлхээ холбоотой байваас зохих бөгөөд онц түргэн бачим хэрэг гарах ахул хүчин туслалцах зэргээр хавсралцан гүйцэтгэвээс зохимуй.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хил хязгаарыг урьдаар нэн чандаар харж сэргийлбээс зохих учраа харьяат цагдаа нар бээр өөрийн барьцаа цагдаа нар лугаа уул эргэж цагдан хянах сэргийлэх газрын хооронд төв дунд газраа тусгай тодорхой тэмдэг босгон цаг хэмжээ тогтоож харилцан зорилдож байцаан үзэх зэргээр сэргийлбээс зохимуй.

Үүнд тайлбарлах нь: Эл тэмдэг босгож газрыг харьяат захирах хошууны тамгын газраас тусгай түшмэл гаргаж үзүүлэн заан тогтоовоос зохимуй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. Харьяат цагдаа нар өөр өөрийн ба орон нутгийн хүмүүс лугаа харилцан хэлхээ холбоог зузаатган элдэв түргэн чухал мэдээ чимээ авалцах аливаа бат баримт бүхий нь улмаар аль ойр нутаг тохиолдох албан газраа урьдаар нэвтэлгэн явуулах зэргээр гүйцэтгэвээс зохимуй.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Аливаа хулгай худлын хэргийг нэгэн адил хянан сэргийлэх ба олз барих зэрэгт аль болохоор туслалцахыг хичээвээс зохимуй.

ХЯЗГААРЫГ НЭВТРЭН ЗӨРЧИГЧДИЙГ ХЯНАН СЭРГИЙЛЭХ НЬ:

ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Элдэв дотоод гадаадын хүмүүс тус улсын хил нэвтрэн нааш цааш зорчигсдыг тухай бүр хянан байцааж шударга самууныг ялган салгаж нэвтрүүлэн өнгөрүүлэхийг хориглон зогсоох нь:

Нэг. Зохих албан газраас зөвшөөрөл бүхий үнэмлэх тэмдэгтэй нь нэвтрүүлэн өнгөрүүлэх.

Хоёр. Албаны газраас зөвшөөрөлгүй бөгөөд онц сэжиг учиргүйд нь учир байдлыг ухуулан гэдрэг буцаах ба эсхүл сэжиг учиртайг нь барьж, ойрх албаны газраа хүргүүлэх.

Гурав. Албан газраас зөвшөөрөл бичигтэй бөгөөд гааль хураалгаагүй боловсон ба түүхий эд таваар мал жич цаазтай хорт зүйлсийг авч газар нэвтрэн гарах ба орох этгээдийг уг баримт бичиг лугаа тоо тохируулан үзэж тохирох аваас өнгөрүүлж болмуй. Хэрвээ тоо илүүдэх буюу тасрамдуулан бусад юм ч авахуйг нь уг юмсын хамтаар аль ойрх албаны газраа хүргүүлэн гүйцэтгэн шийтгүүлэх.

Дөрөв. Үнэмлэх зөвшөөрөл бичиггүй бөгөөд ийм зүйл авч явах этгээдийг шууд барих ойрх албаны газраа хүргүүлэн нэгэн адил гүйцэтгэн шийтгүүлэх.

Тав. Зөвшөөрөл бичигтэй бөгөөд онц хэрэг бүхий этгээдийг нэгжин байцаах хэмээх зүйл үгүй уг үнэмлэх бичгээр баримт болгон шууд өнгөрүүлбээс зохимуй.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. Гадаадын хүмүүс тус улсын зах хязгаарын дотор дур зоргоор нүүдэллэн орж нутаглах ба мал адуулах, ой мод дэлхийн баялгийг зохих газрын зөвшөөрөлгүйгээр ашиглах явдлыг урьдаас хянан харгалзаж хориглон зогсоовоос зохимуй. Хэрвээ эс ойшоон түрэмгийлэх нь буй аваас зохих газраа мэдүүлэн хариу заавар ирэхийн янар аль болох аргаар хориглохыг бодолхийлсугай.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Ямар зэрэг учраар хязгаар нэвтрэн ирсэн ба явагсад хориглон буцагсад албаны газраа хүргүүлсэн хүмүүс хэд хэчнээн болохыг тусгай тодорхойгоор бүртгэн зах хязгаарыг эргэх хэргээр одогчид харьяа захирах албаны газар гурваад сар тутам нэгэн удаа илтгэх буюу мэдэгдвээс зохимуй.

ЗЭВСГИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ НЬ:

АРАВДУГААР ЗҮЙЛ. Харьяат цагдаа нар цагдан сэргийлэх явдал гүйцэтгэхүйд хэрэглэх зэвсгийг аймгийн яамнаас Цэргийн Яамнаа мэдүүлж тавин олгуулбаас зохимуй. Гагцхүү харьяат цагдаа нар юуны урьд зэвсэг хөдөлгөхгүйг ихэд болгоомжлон онц арга сэдвийг олж гүйцэтгэхийг хичээвээс зохимуй.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Буу зэвсэг чухам ямар байдалд хэрэглэвээс зохихуй нь:

Нэг. Дотоод гадаадын харьяат зэвсэг бүхий хулгайчин, дээрэмчин, оргодол хязгаараас халдан ирэх, нэвтрэн орох.

Хоёр. Зэвсэггүй боловч олноороо бүлэглэх буюу ганцаар боловч хүчирхэн эсэргүүцэх бөгөөд хэрхэвч зогсоон үйл чадах ба хүний амь биед аюул хорлол хүргэх этгээд.

Гурав. Аливаа дотоод гадаадын харьяат олон хүмүүс бүлэглэн улсын цааз хуулийг зөрчиж буу зэвсгийг хэрэглэн эсэргүүцэх.

Дөрөв. Аливаа дотоод гадаадын хүмүүс зохих газрын зөвшөөрөлгүйгээр нааш цааш хил хязгаарыг зоригоор нэвтрэн одоход хориглохүйд эсэргүүцэх буюу шууд зугтан үл гүйцэгдэх

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Ийнхүү зэвсэг хэрэглэхүйд эрхбиш хэргийн байдлыг сайтар хянан завдан бүхийд нь урьдаар мэдээ болгон дээгүүр буудах ба шууд алахгүйгээр хүчийг мохохыг хичээвээс зохимуй.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Харьяат цагдаа нар энэхүү дүрмийг зөрчиж албаны чухлыг эс ойшоон цалгардуулах буюу зоригоор буу зэвсэг хэрэглэн хэрэг төвөг өдүүлэх зэрэгт хүргүүлбээс даруй хууль цаазын ёсоор хүндэд цээрлүүлэн шийтгэмүй.

ГАЗАР ОРНЫГ ХАРЬЯЛАХ АЛБАН ГАЗРЫН ДАГАЖ ГҮЙЦЭТГЭХ НЬ:

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Харьяат аймаг хошуудын гадаад лугаа зах нийлсэн хил хязгаарыг сэргийлэн хамгаалуулахаар цагдаа нарыг суулгахуйдаа уул зураг өгүүллийг баримтлан цагдах газруудад хил хязгаарыг чухал боомтыг харгалзан суулгах боловч тухай бүр газар орны байдалд нийлүүлэн жич тоо тогтоох зэргээр хянан гүйцэтгэвээс зохимуй.

Үүнд нэмэн тайлбарлах нь: Эдгээр цагдаа нарыг нутгийн харьяат аймаг хошуудаас эрхлэн захирах боловч заавал нутаг тохиолдох хошуу бүрт захируулах хэмээх явдалгүй эрхбиш эмхтгэхийг эрхэлж тэдний өрх суурийн олон цөөн нутаг газрын байдлаар тэнцүүлэн чухам аль аль хэдэн хошуунд захируулах явдлыг аймгийн яамнаас нэр, тоо тогтоон хуваан захируулж болмуй.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. Эл зах хязгааруудаар чухам ямар нэртэй газар хэчнээн цагдаа нарыг суулгасан хэрхэн захируулсан зэргийг тодорхойгоор зураг цэс үйлдэж аймгийн яамнаас дотоод, гадаад цэргийн яам, дотоодыг хамгаалах газар нэгэн адил мэдүүлэн явуулах зэргээр байцаан тэмдэг болговоос зохимуй.

АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Эл цагдаа нар бээр уг ногсон үүргийн доторх хэргийг бүрнээ төгөлдөр гүйцэтгэн буй үгүй зэргийг давхар хянан магадалж хэрхэн **дуурч** заавар тушаалыг өгөх зэргээр цаггүй цагдан сэргэж сэргийлэх ба сэргийлбээс зохимуй.

АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хэрвээ булаалдан тэмцэлдэж бүхий газар буй аваас зохих газраа мэдүүлэн тухай заавар тушаалыг хүлээх зэргээр ашиг шимийг алдагдуулахгүйгээр хянан шүүж сэргийлбээс зохимуй.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Тус хил цагдахаар суулгасан цагдаа нарын хүч хөрөнгө цагийн гачаал элдэв зүйлээс мөхөөснийг нь сэлбэх, зузаатгах зэргээр тэгшитгэх явдлыг цаг тухайд чухалчлан гүйцэтгэж байваас зохимуй.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Хэрвээ зарим хил хязгаарын газраа түгшүүртэй чимээ гаргах ахул үнэн мөнийг сайтар хянан мэдэж зохих газраа мэдүүлэн нэгэнтээгүүр цагдаа нарын дээр хүчин нэмэх ба ойрх албаны газраа мэдүүлж хүчин хавсралцаж туслалцуулах алин болох аргыг хэрэглэн хил хязгаарыг чандлан сэргийлэн хамгаалбаас зохимуй.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ. Хэрвээ энэхүү дүрэмд заасныг үл дагах зэргээр эл хил хязгаарыг цагдах сэргийлэх явдлыг осол цалгар болговоос зохигчдыг хэргийн байдлыг хянан харгалзаж хууль дүрмийн ёсоор хүндэд цээрлүүлэн шийтгэмүй.

Монгол улсын 18 дугаарын 9 сарын хорин дөрөвнөө

Энэхүү дүрмийг засгийн газрын 27 дугаар хурлын тогтоолын нэгдүгээр зүйл ба улсын бага хурлын төлөөлөгчдийн 61 дүгээр хурлын нэгдүгээр зүйлд тус тус баталжээ.

Жалбасүрэн бичээд Донойдорж хянав.